



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 21 өдөр

Дугаар 4/558

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэг 1 дэх заалт, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйл 17.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Дэлхийн зөн Монгол Олон Улсын байгууллагаас хэрэгжүүлэх “Мөнх ногоон ой” төслийг Ойн менежментээр дамжуулан зорилтот бүлгийн иргэдийн амьжиргааг нэмэгдүүлэх зорилгоор Алаг-Эрдэнэ суманд хэрэгжүүлэхийг дэмжсүгэй.

2.Төслийн үйл ажиллагааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж хамтран ажиллах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3.Сумын Засаг даргын Захирамжаар дэд ажлын хэсэг байгуулан ажиллахыг Алаг-Эрдэнэ сумын Засаг даргад, төсөлтэй холбоотой шаардлагатай мэдээ мэдээлэл өгөх, арга зүйн дэмжлэг үзүүлж хамтран ажиллахыг ажлын хэсгийн ахлагчид тус тус үүрэг болгосугай.

4.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Аймгийн Засаг даргын 2024 оны
10 дугаар сарын 21-ний өдрийн /сдд/ тоот
захирамжийн хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүдэд:

Байгаль орчны газрын дарга
Алаг-Эрдэнэ сумын Засаг дарга
Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга
Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
Хөвсгөл нуур эгийн голын сав газрын захиргааны дарга
Дэлгэрмөрөн сум дундын ойн ангийн дарга
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт,
хөрөнгө оруулалтын хэлстийн байгаль орчин, аялал жуулчлал, уул уурхайн бодлого
үйл ажиллагааг зохион байгуулах мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Д.Саранцогт (Дэлхий зөн Монгол ОУБ-ын “Мөнх ногоон ой” төслийн орон
нутгийн зохицуулагч)

_____оОо_____